



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар Р/773

Арвайхээр

Нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулах тухай

Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалт болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зүүнбаян-Улаан суманд баригдсан Спорт заалны барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Смарт зоос” ХХК-ийн гүйцэтгэж буй ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй зам талбай, биеийн тамирын тоног төхөөрөмжийн ажлыг нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.

2. Нэмэлт гэрээ байгуулж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-д даалгасугай.

3. Нэмэлт ажилд шаардагдах 10.935.442 (арван сая есөн зуун гучин таван мянга дөрвөн зуун дөчин хоёр) төгрөгийг Сангийн яаманд уламжлан тендерийн үнийн зөрүү зардлаас шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.



Т.ГАНБОЛД

011101479